

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ТӨРИЙН ҮҮРЭГ ОРОЛЦОО

Нийгэм судлал 10-р анги

II улирал. Хичээл №5

[Email: D.Urantsetseg@must.edu.mn](mailto:D.Urantsetseg@must.edu.mn)

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- Макро эдийн засгийн асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэхэд төрийн үүрэг оролцоог онолын мэдлэгт үндэслэн судлах
- Түүхэн янз бүрийн үеүдэд төрийн эдийн засагт гүйцэтгэж байсан үүргүүдийг тохиолдол дээр шинжлэх

.

ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Макро эдийн засаг (Грекээр "макро" гэдэг нь "том" гэсэн утгатай) гэдэг нь эдийн засгийн **бүтэц, үйл хөдлөл, шийдвэр гаргалт, үр дүнг бүхэлд** нь нэгтгэдэг эдийн засгийн салбар юм.
- **Улсын төсөв, Татвар, Экс Им. ДНБ, Үнийн инд, ҮНБ, Ажилгүйдэл, имфляци**
- Албан татвар” гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил-үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

ОНОЛЫН ХЭСЭГ

- Макро болон микро эдийн засаг нь эдийн засгийн хамгийн нийтлэг хоёр салбар юм.
- Микро эдийн засаг нь хувь хүн болон ААН-ийн шийдвэр гаргалтын үйл хөдлөлийг судалдаг.
- Макро эдийн засаг нь дотоодын нийт бүтээгдэхүүн, ажилгүйдэл, инфляци, үндэсний орлого, үнийн индекс болон салбаруудын хамаарал зэрэг том үзүүлэлтүүдийг судалдаг.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ТӨРИЙН ҮҮРЭГ

Нийгэм-эдийн засгийн амьдралд байгаа зохицуулж чадахгүй асуудлуудыг төр гүйцээн шийдвэрлэж өгдөг учраас эдийн засаг тогтвортой өсч хөгжих боломжтой болдог.

Төрийн үүрэг

- 1. Эдийн засгийн амьдралын хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэх**
- 2. Нөөцийг хуваарилах**
- 3. Төгс өрсөлдөөн өрнөх таатай болмж бүрдүүлэх**
- 4. Орлогыг дахин хуваарилах**
- 5. Эдийн засгийг тогтворжуулах нь**

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛЧИД



Сонгодог эдийн засгийн онолыг үндэслэгч Английн нэрт эдийн засагч Адам Смит(1723-1790) “Ард түмний баялаг” гэдэг алдарт бүтээлдээ “Төр татварын бодлогоор дамжуулан нийгмийн харилцааг зохицуулах чиг үүргээ хангадаг бөгөөд чөлөөт эдийн засгийн салшгүй чухал зүйл бол татвар юм” гэдэг онол гаргасан



Британийн эдийн засагч Дж.М.Кейнс /1883-1946/ нь орчин үеийн макро эдийн засгийн онол ба практикт чухал хувь нэмэр оруулсан юм.Тэрээр бизнесийн мөчлөгийн талаарх хуучин ажлыг засаж сайжруулсан ба эдийн засгийн уналт ба зогсонги байдлын сөрөг нөлөөг бууруулахын тулд мөнгөний хэмжүүрийн хэрэглээг дэмжиж байв.

А.Смит-Татвар Чөлөөт эдийн засгийн үед макро Төрийн бага хамааралтай

М.Кейнс-Мөнгөний хэрэглээг дэмжсэн. Төрийн оролцоо 100%

МОНГОЛ ОРНЫ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО

- Монгол нутагт анхны төрт улс байгуулагдсан үеэс, Монголын Эзэнт Гүрний үе хүртэл торгоны замаар дамжуулан гадаад оронтой гадаад худалдаа хөгжүүлэх зэрэг арга хэмжээг төрийн бодлогоор авч хэрэгжүүлж байсан нь тухайн үеийн эдийн засагт төр хүчтэй нөлөөлж байсны илрэл юм.
- Өнөөгийн эдийн засаг дахь төрийн оролцооны онцлог нь **Чөлөөт зах зээлийг сонгодог эдийн засгийн онолын дагуу хөгжүүлэхээр хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байгаа явдал юм.**

Тохиолдол шинжлэх-1 (хариултыг дэвтэртээ бичнэ.)

1929 оны хямрал нь эхэн үедээ АНУ-д бүх нийтийн ажилгүйдэл, зах зээл дээрх түүхий эдийн болон ХАА-н бүтээгдэхүүний үнэ ханшийн уналтаар өрнөж ,хормын зуур Герман,Дорнод Европ ,Африк,Ази,Латин Америк, Австралийг ч нөмөрсөн байдаг. Тухайн үед Жон Мейнард Кейнс: Хэрвээ инфляци хаалгыг чинь тогшиж байгаа бол гэмтэн нь хүн амын “хэт их зарлага” дотор нуугдаад сууж буй учир түүнийг илааршуулах эмчилгээний аргыг “Үндэсний эдийн засгийг тогтворжуулагч, зохицуулагч” хэмээн өөрийгөө зарлан тунхагласан Засгийн газарт бичиж өгчээ.

Хариулт: Энэ үед төрөөс ямар ямар арга хэмжээ авах талаар бичнэ үү.

1.

2.

Тохиолдол шинжлэх-2 (хариултыг дэвтэртээ бичнэ.)

Герман төдийгүй бүх Европ хэрэгцээнээсээ хамаагүй бага үйлдвэрлэл явуулж дээр нь их хэмжээний өрөнд баригдсан, хэн ч, юу ч худалдан авч чадахгүй болтлоо дампуурсан байжээ. Дайтаж явсан хэдэн зуун мянган цэрэг эрс, юу ч үгүй болтлоо сүйдэж балгас болсон хотууд, сэтгэл санааны гүн дарамттай, идэх хоол, өмсөх хувцасгүй ард түмнийг хэрхэн, юугаар хооллож, ирээдүйгээ яаж бий болгох вэ?

Хариулт:

Тохиолдол шинжлэх-3 (хариултыг дэвтэртээ бичнэ.)

1970-аад оны хямрал нь капитал гаргах өөр газар нутаг, улс орон дууссан байсан тул илүүдэл капиталыг “үгүй хийх” шаардлага гарч ирсэн , мөн борлуулалтын зах зээлийн өсөлт нь нэгэнт зогссон тул хөгжлийн явц огцом хүндэрсэн байна. Энэ бүхний эцэст системийн шинжтэй том хямрал үүссэн билээ. 1971 онд АНУ долларын алтан баталгааг цуцлаж Холбооны Нөөцийн Банкны цаасан дэвсгэрт болгосон юм. Үүний дараа 1973 онд нефтийн хямрал эхэлсэн билээ. Уг хямралын үе нь дэлхий нийтийг 2 лагерт хуваагаад байсан хүйтэн дайны нөхцөл байдлыг улам дэвэргэж байлаа. Энэ үеэс л эдийн засгийн салбарт А.Смитын дэвшүүлсэн Үл үзэгдэгч гарын онолыг тууштай хэрэгжүүлсэн юм.

Хариулт :

ДУГНЭЛТ

- Үндэсний үйлдвэрлэл, бүтээн байгуулалтыг дэмжих, хамгаалах зорилгоор **татварын 12-19 Лаффер** болон **зээлийн 3%** бодлогыг оновчтой хэрэгжүүлэх
- Валютын нөөцийг бий болгохийн тулд хувийн хэвشلүүдийг бодлогоор дэмжиж дэлхийн тавцанд гаргах
- Зах зээлийн эдийн засаг, чөлөөт өрсөлдөөнийг хамгаалах зорилгоор хуулийг илүү нарийн зохицуулалттай болгох
- Шууд болон шууд бус хөрөнгө оруулалттай